

БАРИЛГЫН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ЖИЛИЙН  
ЭЦСИЙН ТАЙЛАН



УЛААНБААТАР ХОТ- 2021 ОН

## БАРИЛГЫН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

### НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

1.1 Барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулж, улсын хэмжээнд байгаа түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг үе шаттайгаар бэхэлж, хүчитгэх, шинэчлэх зорилтод ажил: “Түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл”-ийн нэгжид хүчитгэх, шинэчлэх шаардлагатай түүх соёлын дурсгалт 5 барилгын тайлан, дүгнэлтийг албан бичгээр хүргүүлэв. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх журамд 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр цахимаар санал хүргүүлэв.



1.2 2002 оноос өмнө баригдсан орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах ажлыг үргэлжлүүлэх, хэмжилтийн иж бүрэн багаж хэрэгслээр хангах зорилтод ажил: 2002 оноос өмнө баригдсан барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах ажлыг үргэлжлүүлэх, хэмжилтийн иж бүрэн багаж хэрэгслээр хангах ажлын хүрээнд 39 барилгын зураг төслийг бэлдэж, 24 барилгад биет, хэмжилт судалгаа хийсэн. 16 барилгад паспортжуулалтын гаргав.

2002 он хүртэл баригдсан орон сууц болон олон нийтийн барилгын судалгааг тодотгон, жагсаалтыг шинэчлэв. Угсармал барилгыг дулаалах төсөлтэй холбоотойгоор 77 барилгын жагсаалтыг гарган газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийлгэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж өгөх талаарх саналыг Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг

сайжруулах хоёрдугаар төслийг удирдах нэгжид хүргүүлэхээр Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэст бэлдэж өгсөн.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн нэгжид шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн танилцуулга, жагсаалт, судалгааг хүргүүлсэн



1.3 Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, олон нийтийн барилгын хүчитгэлийн зураг, стандартын шаардлага хангасан амины сууцны нэг маягийн загвар зургийг боловсруулах зорилтод ажил: Орон сууц болон төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль цэцэрлэг, олон нийтийн барилгын хүчитгэлийн зураг, Гамшгийн эрсдэлд тэсвэртэй амины сууцны загвар зураг боловсруулах төсвийн саналыг



Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Нийслэлийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд тусгах санал боловсруулж албан бичгээр тус тус хүргүүлэн амины сууцны загвар зураг боловсруулах ажлын төсөв 2022 оны нийслэлийн төсөвт тусгагдсан. Зургийн даалгавар боловсруулах техникийн бичиг баримтыг судалж байна. Мөн эхний ээлжид хүчитгэх 15 барилгын жагсаалтыг урьдчилсан байдлаар гаргав.



1.4 “Барилга байгууламжийн чанарын улсын зөвлөгөөн 2020”-өөс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.4 Барилгын ажлын чанар хяналтын тогтолцооны эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтод ажил: Хэлтсийн үйл ажиллагаанд мөрдөж буй “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”, “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”, “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”, “Барилга, байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм”-ийг шинэчлэх, дүрэм,

журамд тусгах саналаа цахимаар болон албан бичгээр Барилга, хот байгуулалтын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн бөгөөд бүгд шинэчлэгдэж батлагдсан. Мөн Нийтийн Мэдээллийн тухай хууль, газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх БНБД-22-01-21-ийн тайлбар, Салбарын үйл ажиллагаанд дагаж мөрддөг бусад 2 төрлийн норм, дүрэм, стандарт, техник зохицуулалтын баримт бичигт санал өгөв.

ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:



2.1 Нийслэлийн Түр хоргодох орон байраар хангах албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг жил бүр тодотгох зорилтод ажил: Нийслэлийн Түр хоргодох орон байраар хангах албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бэлтгэл, бэлэн байдлыг хангах хэсэгт тодотгол хийж, 2020 оны үйл ажиллагааны тайлан, албаны чиг үүрэгтэй холбоотой танилцуулгыг, гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулж байгаатай холбоотой Нийслэл хотын барилга, байгууламжийн статистик мэдээллийг тус тус гарган Нийслэлийн Онцгой байдлын

газарт хүргүүлэв.

-Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Нийслэлийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах, ажиллах журам батлах тухай” А/247 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Түр орон байраар хангах албанд тайлагнаж хамтран ажиллах талаарх үүргийг Газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 05/3851 дүгээр албан бичгээр Нийслэлийн Боловсролын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газарт хүргүүлсэн.

-Нийслэлийн түр хоргодох орон байраар хангах албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бэлтгэл, бэлэн байдлыг хангах хэсэгт тодотгол хийж нийт албан хаагчдын гэрийн хаяг, холбоо барих утасны жагсаалтыг шинэчлэн, үүрэн холбоо болон биет зарлан мэдээлэх схемийг шинээр боловсруулан 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр газрын даргаар батлуулав. Үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх илтгэх хуудсыг 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн Онцгой байдлын газарт хүргүүлж ажиллав.

-Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх ажлуудад шаардлагатай санхүүжилтийн санал бэлдэж Нийслэлийн Засаг даргын тамгын газарт цахимаар хүргүүлэв.

-Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх ажлуудад шаардлагатай санхүүжилтийн саналыг Нийслэлийн Онцгой байдлын газарт /ozao.mn@gmail.com/ цахимаар хүргүүлэв.

-Газар хөдлөлтөд тэсвэргүй, хийц, бүтээц нь ослын байдалтай 66 барилгад зохих арга, хэмжээ авах хүсэлтийг албан бичгээр Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын яам, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Татварын газарт хүргүүлсэн.


- Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлт ирүүлсэн 47 иргэн, аж ахуй нэгжийн хүсэлт, баримт бичгийн бүрдлийг судалж хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллав



2.2 Барилгын газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт төлбөртэй үнэлгээ хийх, насжилтыг тодорхойлох, эрсдэлтэй объектуудын зориулалтыг өөрчлөх, хүчитгэх, эсхүл буулгах санал гаргах зорилтод ажил: Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 17 барилгын газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт төлбөртэй үнэлгээ хийж, иргэн хуулийн этгээдэд дүгнэлтийг хүргүүлэв. Нийт 22.201.200 мянган төгрөгийг төсөвт

төвлөрүүлсэн. Газар хөдлөлтөд тэсвэргүй, хийц, бүтээц нь ослын байдалтай 66 барилгад зохих арга, хэмжээ авах хүсэлтийг албан бичгээр Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын яам, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Татварын газарт хүргүүлсэн.

2.3 Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох зорилтод ажил: Барилгын тухай хууль, Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэмд заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 841 барилгын ажлын зөвшөөрөл шинээр олгож, 204 барилгын зөвшөөрөлд сунгалт хийж, 4 барилгын зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулсан. Дундаж шийдвэрлэлтийн хугацаа 12.2 хоног байна.



#### ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:



3.1 Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах ажил: -Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2010 оны 10/03 дугаар хуралдааны тэмдэглэлийн биелэлт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн биелэлт, -Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Засгийн газрын гишүүн Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт,

Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт, Засаг даргын ажлын 100 хоногийн биелэлт, Нэгжийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан, Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, Нийслэлийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, Нэгжийн 7, 14 хоногийн тайлан, Нэгжийн улирал, хагас жил, жилийн эцсийн гүйцэтгэл, тайлан, Шуурхай үүрэг даалгаврын биелэлт, Нэгжийн үйл ажиллагаатай хамааралтай бусад ажлын тайлан, мэдээг цаг хугацаанд нь гаргаж ажиллав.



**3.2 Нэгжийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, ажиллах:** Нийслэлийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн 2021 оны эхний хуралд Барилга байгууламжийг паспортжуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны танилцуулга бэлдсэн. 2018 оноос хойш барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ авсан орон сууцны барилгын мэдээлэл, Барилгын

ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгосон нийт иргэн, аж ахуй нэгжийн мэдээлэл, жагсаалтыг Барилга, хот байгуулалтын яаманд тус тус цахимаар хүргүүлсэн. Цагдаагийн Ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 11и-1/7616 дугаартай бичгийн дагуу 2019-2020 онуудад Зөвшөөрөлгүй баригдсан Нийслэлийн Засаг даргын 121 дүгээр захирамжийн хүрээнд судалгаа хийж дүгнэлт гаргасан барилгуудын жагсаалтыг хүргүүлэв. Нийслэлийн Дотоод аудитын газраас гүйцэтгэлийн аудит орж байгаатай холбоотойгоор 2019-2021 онуудад олгосон Барилгын ажлын зөвшөөрөл, Байнгын ашиглалтад оруулах комисс ажиллаж дүгнэлт баталгаажсан барилга байгууламжийн нэгдсэн судалгааг бэлдэж өгсөн. Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/632 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогчийн 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн удирдамжийн хүрээнд ирсэн шалгалтын бүрэлдэхүүнд 2019-2021 онуудад олгосон Барилгын ажлын зөвшөөрөл, олгосон барилга байгууламжийн нэгдсэн судалгааг зориулалтаар нь ангилж бэлдэж өгөв. Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/632 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогчийн 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн удирдамжийн хүрээнд ирсэн шалгалтын бүрэлдэхүүнд 2019-2021 онуудад олгосон Барилгын ажлын зөвшөөрөл, олгосон барилга байгууламжийн нэгдсэн судалгааг гаргаж өгөв.



**3.3.Нэгжийн үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээдэд шуурхай хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах:** -2021 оны 03 дугаар сарын 26-ны өдөр ТВ-9 телевизээс зохион байгуулсан хэлэлцүүлэгт Барилга байгууламжийг паспортжуулах ажлын талаар танилцуулга бэлдсэн. 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Улаанбаатар хотын хуучны барилга байгууламж,

паспортжуулалтын ажлын талаар ТВ-5 телевизэд Утасаар мэдээлэл өгөв. Нийслэл мэдээ пэйж хуудаст барилгын аюулгүй ажиллагааны талаар болон түр хашааны талаар 4 удаа мэдээ, мэдээлэл оруулсан.



**3.5 Нэгжийн үйл ажиллагааны төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөх, санал өгөх, Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалд ан авах ажил, зөвлөх үйлчилгээний үнэлгээний хороонд орж ажиллах, ажлын даалгавар боловсруулах, гэрээний төсөл боловсруулах:** - “Нийслэлийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөө”-нд 2022 онд

хэрэгжүүлэх 4 ажлын саналыг 4 төрлийн хавсралт маягтын дагуу боловсруулан хүргүүлж, 2 арга хэмжээний төсөв батлагдсан. Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/189 дүгээр захирамжаар Барилга, байгууламжийн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж паспортжуулах ажилд 74.5 сая төгрөг батлагдсан. Батлагдсан төсвийн хүрээнд багц-2: Багана, дам нуруу, хучилт, дээвэр, тэдгээрийн холбоосны угсралт болон ашиглалтын төлөв байдлыг тодорхойлж дүгнэлт гаргах ажлын гүйцэтгэлийг хянаж үлдэгдэл санхүүжилт болох 20.126.200 төгрөг, багц-4: Барилгын буурь хөрсөнд инженер-геологийн дүгнэлт гаргах ажлын гүйцэтгэлийг хянаж үлдэгдэл санхүүжилт болох 36.806.800 төгрөгийг тус тус олгосон. Багц-1: Тоосго, зуурмагийн дээж авч лабораторид шинжилгээ хийх ажлын 11.880.000 төгрөг, Багц-3: Барилгаас тоосго зуурмагийн дээж авсны дараа нөхөн сэргээн засварлах ажлын гүйцэтгэлийг хүлээн авч эхний санхүүжилт болох 5.687.000 төгрөгийг 2021 онд багтааж олгохоор ажиллаж байна.



3.6 Нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнд хүрэх бодитой ажил санаачлан хэрэгжүүлэх: Газрын даргаар 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлын зөвшөөрөл авч барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа иргэн, аж ахуй нэгж, байгууллагын барилгын түр хашаа, хамгаалалтын торыг норм, дүрэм, зураг төсөл, стандартад нийцүүлэх, орчны аюулгүй байдлыг хангуулах хяналт, шалгалт хийх удирдамжийг батлуулав. Хяналт шалгалтыг 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 09-ний өдрүүдэд 158 байгууллагын үйл ажиллагаанд хяналт хийж, зөвлөн чиглүүлэх ажлыг гүйцэтгэв.

3.7 Авлигатай тэмцэх хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах: Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу нэгжийн бүх албан хаагчид ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргасан.



3.13 Хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх болон газрын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдах: Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, Улс нийслэлийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийн танилцуулга, албан бичгийн журам, E doc, ERP, өргөдөл гомдлын систем, Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан гарын авлагыг баталгаажуулах, "Өндөр барилгын бүтээц төлөвлөлт Япон улсын туршлага", "Улаанбаатар хотын барилга байгууламжийн эрсдэлийн үнэлгээ" сэдэвт лекц, "Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийг хэрэглэх, стандарт норм дүрмийн хэрэгжилтийг хангах нь", Түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчин, газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ, хүчитгэх арга зам сэдэвт 7 төрлийн сургалтад нэгжийн албан хаагчид тус тус хамрагдав. 1 албан хаагч архитектурын чиглэлээр магистрын зэрэг хамгаалахаар суралцаж байна. Мөн 1 албан хаагч Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрх зүйн ангийг бакалавр зэрэгтэй төгссөн бөгөөд 1 албан хаагч "Олон төрлийн хийцлэл бүхий арматуртай багана дам нурууны уулзварын бүтээцийн шинж чанарын үзүүлэлтийн тоон үнэлгээ" гэсэн судалгааны ажлаар "Concrete structures for resilient society" сэтгүүлд бүтээл хэвлүүлсэн. Бүх албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаанд хамрагдсан. Сүүлийн хагас жилд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй 7-4-10 сургалтад нэгжийн албан хаагчид тогтмол хамрагдаж байна. Барилгын хөгжлийн төв, Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий

хотын шинэчлэл салбарын төслөөс 2021. 11.22-23-ны өдрүүдэд зохион байгуулсан /EDGE/ Ногоон барилгын программ хангамж, стандарт, үнэлгээний системийн сургалтад 5 албан хаагч хамрагдсан.

3.14 Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах:

-Нэгжийн хэмжээнд үйл ажиллагааны чиг үүрэгтэй холбоотой асуудлаар иргэн, аж ахуй, нэгжээс 260 өргөдөл, гомдол ирүүлснээс:

-Шийдвэрлэсэн нь : 257

-Шийдвэрлэхээр судалж байгаа: 3

-Шийдвэрлэлтийн хугацаа: 11 хоног

-Иргэн, аж ахуйн нэгжээс 522 албан бичиг ирүүлснээс:

-Шийдвэрлэсэн нь :627

-Шийдвэрлэхээр судалж байгаа: 16

-Шийдвэрлэлтийн хугацаа: 10 хоног



3.16 Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2020 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг батлагдсан хуваарьт хугацаанд холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөх: 2020 оны үйл ажиллагааны баримт бичгийн 195 боть материалыг хүлээлгэн өгөв. Газрын даргын 2021 оны А/26 дугаар тушаалын дагуу 2021 оны 09 дүгээр сард 49 хавтаст /900 гаруй хувийн хэрэг/ материалыг цахим хэлбэрт оруулж, архив зүйн техник боловсруулалт хийв. Мөн 2013-2020 он хүртэлх барилга байгууламжийн байнгын ашиглалтад оруулах комиссын акт, дүгнэлтийг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэсэн эсэхийг нягтлав.

ДӨРӨВ .ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

4.1 Хот байгуулалтын үйл ажиллагаанд Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган захиргааны сөрөг акт гарсан тохиолдолд бүртгэлжүүлж мэдээлж ажиллах: Батлагдсан зураг төслийн зөрчсөн, иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрхэд сөргөөр нөлөөлсөн 7 иргэн аж ахуйн нэгжид олгосон барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг түдгэлзүүлсэн. Зөрчил арилгасан 1 Барилгын ажлын зөвшөөрлийг түдгэлзүүлснийг сэргээсэн. Барилгын тухай хууль зөрчсөн 72 иргэн, аж ахуйн нэгжид зөрчил арилгуулах тухай шаардах хуудас өгсөн.



4.5 Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх, ил тод байдлыг хангах, мэдээллийг цахимжуулах. Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлт ирүүлсэн 1170 иргэн, аж ахуй нэгжийн хүсэлт, баримт бичгийн бүрдлийг судалж хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллав. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн жагсаалтыг тогтмол хөтөлж, Барилгын ажлын зөвшөөрөл шинээр олгосон 278 иргэн, аж, ахуй нэгжийн зөвшөөрлийг Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэв. Мөн Газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/85 дугаар тушаалын дагуу Хот байгуулалтын мэдээллийн санд 2013-2020 онд дутуу шивэгдсэн, Барилгын ажлын зөвшөөрөл /557

барилга/, улсын комиссын /69 барилга/ мэдээлэл зэрэг нийт-626 барилгын мэдээллийг нөхөн бүрдүүлэх ажлыг хийж гүйцэтгэв. Газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 04/1736 дугаар албан бичгээр Барилгын ажлын зөвшөөрөл олгох, сунгах үйлчилгээг төрийн нэгдсэн портал e-mongolia-д шилжүүлэх хүсэлтийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн. Энэ хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Аствишн ХХК-аас 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүсэлт хүлээн авах, шийдвэрлэлтийг хянах программын хөгжүүлэлтийн талаар танилцуулсан. 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Засаг даргын зөвлөлийн хурлаар Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн хүсэлтийг цахимд шилжүүлэх ажлыг зөвшөөрсөн. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл шинээр олгосон, сунгалт, нэмэлт өөрчлөлт хийсэн иргэн, аж, ахуй нэгжийн жагсаалт мэдээллийг байгууллагын цахим хуудаст 12 удаа байршуулав.




Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран үзлэг шалгалт зохион байгуулах: Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/121 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу зөвшөөрөлгүй баригдсан 102 барилгын асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/295 дугаар захирамж батлагдав. Үүнээс:

- Буулгах шийдвэр гарсан 22 барилга /хяналт хэрэгжүүлэгч байгууллагад үүрэг болгож судалж байгаа/
- Хууль тогтоомжид нийцүүлэн архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон-12, Загвар зураг баталсан-3,
- Барилга угсралтын ажлаа бүрэн гүйцэтгэн дуусаж, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажилласан 4 барилга
- Бичиг баримтын бүрдэл хангуулж, зөрчил арилгуулсан 20 барилгад барилгын ажлын зөвшөөрөл олгов.
- Барилгын ажлын зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 2 барилгын бичиг баримтын бүрдлийг хянаж байна.


Үлдсэн 39 барилгын захиалагч, гүйцэтгэгч нарт зөрчлөө арилгах талаар зөвлөгөө өгч ажиллаж байна.

2021 онд иргэн, аж, ахуй нэгжийн ирүүлсэн хүсэлтийг судалж 42 барилгад баригдсан учир нөхөж Барилгын ажлын Зөвшөөрөл олгохгүй талаар албан бичиг явуулж, 35 иргэн, аж ахуй нэгжид зөрчлийг таслан зогсоох талаар албан бичгийг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлсэн.



**4.7.Паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргасан барилгуудын мэдээллийг мэдээллийн санд бүртгэх, боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, газар хөдлөлтөд эрсдэлтэй, тэсвэргүй, барилгуудын дүгнэлт, мэдээллийг /зориулалтыг өөрчлөх, хүчитгэх, эсхүл буулгах санал/ холбогдох байгууллагад хүргүүлэх, сургалт зохион байгуулах:** Зайлшгүй мэргэжил дээшлүүлэх шаардлагатай 7 төрлийн сургалтын санхүүжилтийг шийдэж өгөх талаар хүсэлт саналыг “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн нэгжид хүргүүлсэн. -Бетон материал, бүтээц, байгууламжийн орчин үеийн судалгаа, туршилт сэдэвт семинарт 1 албан хаагч хамрагдсан. Нийслэлийн Онцгой байдлын газрын болон дүүргүүдийн онцгой байдлын хэлтсийн албан хаагчдад “Ашиглагдаж байгаа барилга байгууламжийн чанар, аюулгүй байдал” сэдвээр сургалт явуулав. Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар тушаалаар “Барилга, байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах” журмын 4.5, 4.6, 4.7, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн Барилга, байгууламжийн бат бэх,





найджаржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган паспортжуулах эрх бүхий хуулийн этгээдийг мэргэжил арга зүй, удирдлагаар хангах, техникийн асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах, мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий орон тооны бус “Паспортжуулалтын зөвлөл”-ийг шинэчлэх Захирамжийн төсөл, “Зөвлөлийн дотоод үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг тус тус боловсруулан батлуулахаар ажиллаж байна. 2021 онд Барилга байгууламжийг паспортжуулах, газар хөдлөлтийн үнэлгээ хийж, паспортжуулах ажлын төсөв батлагдаагүй болно.

## ТАВ. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ


Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/25 дугаартай захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах: Нийслэлийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу Хан-Уул дүүргийн 11, 15 хорооны нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагуудаар үйлчлүүлж байгаа иргэдийг QR кодоор бүртгэлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллав. Хатуу хол хорионы үед буюу 2021 оны 02 дугаар сарын 18-22 өдрүүдэд 1 албан хаагч 5 хоногийн эргүүлээр ажиллав. Сүхбаатар дүүргийн 11 хорооны өрхийн эмнэлэгт баталсан хуваарийн дагуу 3 албан хаагч ковид-19 цар тахалтай үеийн тусламж үйлчилгээнд дэмжлэг үзүүлэн ажиллав

Иргэн бүртгэлийн цагийн QR кодыг уншуулах




\* Иргэн нь өөрийн ажилтай байх үедээ COVID-19 өвчний "Байршлын мэдээлэл" цагийн QR код уншигч дээр дарж тодорхой байршилд нэгдсэн "Бүртгэлийн цаг"-ийн QR кодыг уншуулах өөрийн байршлаа гэрчилгээ.

Цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор өгч буй үүрэг даалгавар: Хөвсгөл аймгийн Ханх суманд болсон газар хөдлөлт Улаанбаатар хотод мэдрэгдсэнтэй холбоотойгоор эвдрэлд орсон орон сууц, олон нийтийн зориулалттай 11 барилгын төлөв байдалд шуурхай үзлэг хийж үр дүнг Нийслэлийн Онцгой комисс, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэв. Хан-Уул дүүргийн 75 дугаар сургууль дугуйн зам уруу хашаагаа түрж барьсан зөрчлийг арилгуулав. -БГД-ийн 8-р хороо нарлаг хотхоны 23а байрны 60 тоот айлын даацын хийц, бүтээцэд урьдчилсан үзлэг хийж эвдрэл, гэмтэлгүй тогтоов.




Улсын Онцгой комисс, Нийслэлийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах: Одон орон, геофизикийн хүрээлэнгээс 2021 оны 170 дугаартай албан бичгээр ирүүлсэн

хүсэлтийн дагуу Хүчтэй газар хөдлөлтийн баллыг тодорхойлох багаж, төхөөрөмжийг Улаанбаатар хотын 4 бүсэд суурилуулан урт хугацаанд хамтран хэмжилт, хийж байна.



Нийслэлийн Засаг даргын А/177 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны А/49 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах: Нийслэлийн Засаг даргын А/177 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны А/49 дүгээр тушаалын хүрээнд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газар, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран хяналт шалгалтыг зохион байгуулав. Хяналт шалгалтаар Барилгын үйл

Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авч ажил гүйцэтгэж байгаа барилга байгууламжид хяналт шалгалт хийх: Газрын даргын 2021 оны 05 сарын 20-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2020-2021 онуудад олгогдсон Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгосон 158 байршлаар хяналт, шалгалт хийж зөвлөмж өгч ажиллав.



ажиллагаа эрхэлж буй компаниудад хамааралтай орчны аюулгүй байдал алдагдуулсан 575 зөрчил гарсан бөгөөд 408 зөрчлийг арилгуулсан.

Барилга угсралтын ажил хийгдэж дуусалгүй удаан хугацаанд зогссон, хотын өнгө үзэмжид сөргөөр нөлөөлж буй, орчны эрүүл аюулгүй байдлыг хангуулах шаардлагатай хотын төвд байрлах 10 барилгад Барилгын тухай хуульд заасан хамгаалалтын горимд шилжүүлэх, барилгын түр хашаа, саравчийг стандартын дагуу хийх, төсөл хэрэгжих хугацааг гаргаж ирүүлэх, орчны аюулгүй байдлыг хангуулах тухай зөвлөмжийг албан бичгээр хүргүүлсэн. Эдгээр 10 барилгаас МАК ХХК /Энхтайваны гүүрний урд талд/, иргэн С.Нямдаваа /Төв шуудангийн урд талд/ нарын төлөөлөл тухайн төслийн хэрэгжих хугацаа болон орчны аюулгүй байдлаа хангасан талаар биеэр ирж уулзсан.

Нийслэлийн онцгой комиссоос 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдөр №444 дугаар албан бичгээр ирсэн хүсэлтийн дагуу үерийн усны далан сувгийн хамгаалалтын зурваст өртсөн иргэн, аж ахуйн нэгжийн барилга байгууламжийн судалгааг нэгтгэн гаргав.

“Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр” нь Засгийн газрын 2009 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 157 дугаар тогтоолоор батлагдаж 2009-2014, 2015-2020 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжиж дууссан бөгөөд Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 140 дүгээр тушаалаар хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, дүгнэлт гарган, санал, зөвлөмж боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсэгт Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн ажиллаж хөтөлбөрийн хэрэгжилт, тайлантай танилцаж, 75.8%-ийн үнэлэлт өгч, дүгнэлт гарган, санал зөвлөмж боловсруулан Барилга хот байгуулалтын яамд хүргүүлэн ажлын хэсэгт танилцуулан ажиллав.

, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/63 дугаар тушаалаар байгуулагдсан “Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй нийтийн аж ахуйн

тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн хариуцаж байгаа нийтийн зориулалттай орон сууцны барилгад хамаарах ус, дулаан, ариутгах татуургын түгээх шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн бүртгэл, тооллого явуулах, ашиглалтын байдалд дүгнэлт гаргах, өмчлөгчийг тодорхой болгох ажлыг зохион байгуулах" ажлын хэсэгт орж ажиллаж холбогдох санал, дүгнэлтийн гаргасан.

Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хороо Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 138 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу 8, 11 дүгээр байруудын паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт /Газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийх/ гаргах ажлын даалгаврыг боловсруулж цахимаар хүргүүлэв.



Газар хөдлөлтийн эрсдэл, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга бэлдэж Засгийн газрын 2021 оны 11 сарын 03-ны өдрийн хуралдаанд Монгол Улсын Шадар сайд танилцуулан Засгийн газрын 2018 оны Н/206 дугаар тогтоолд заасан Ашиглалтын шаардлага хангахгүй сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилгыг буулгах, шинээр барих ажлыг судлах, 2002 оноос өмнө баригдсан олон нийтийн барилга, байгууламжийг паспортжуулах, гэрчилгээжүүлэх ажлыг эрчимжүүлэхийг даалгаж хуралдааны тэмдэглэл гарсан.

ТАЙЛАН ХЯНАСАН: БАРИЛГЫН ЧАНАР,  
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ТАМИР

ТАЙЛАН ГАРГАСАН:  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.АРДАБЕК

2021 оны 12 дүгээр сарын 14-ний өдөр